**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 02 өдөр Дугаар А/487 Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугээр зүйлийн 60.1.1, 60.1.7, 60.1.21, Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | М.Пүрэвхүү | - Соёл урлагийн газрын дарга |
| Гишүүд : | Г.Жавзанхорлоо | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн /зөвшилцлөөр/ |
| | Б.Уртнасан | - Соёл урлагийн газрын Соёлын өвийн Мэргэжилтэн |
| | Ц.Алтанхишиг | - Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч |
| | Т.Гэрэлмаа | - Музейн дарга |
| | Н.Уламнэмэх | - Музейн бүртгэл мэдээллийн санч |
| Нарийн бичгийн дарга: | Д.Гантуяа | - Соёл урлагийн газрын Соёл урлагийн хэлтсийн дарга |

2. Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх ажлыг 2022 оны 08 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 30-ны хооронд журмын дагуу чанартай

8400 01 2459
Zah A/487 tum

зохион байгуулж, тооллогын дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд 11 дүгээр сарын 01-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Пүрэвхүү)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.

Б.ДҮГЭРЖАВ